



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар #/49

Улаанбаатар хот

┌ Шөнийн нийтийн тээврийн үйлчилгээ ┐
эхлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зуны улирал эхэлсэнтэй холбогдуулж Улаанбаатар хотын иргэдийн шөнийн цагаар зорчих эрэлтийг хангасан, аюулгүй, найдвартай тээврийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор үндэслэн шөнийн нийтийн тээврийн үйлчилгээний ШҮ:1 “5 шар-Ботаник” чиглэлийн замналыг нэгдүгээр, ШҮ:2 “Нисэх-МУБИС-Ард кино театр” чиглэлийн замналыг хоёрдугаар, ШҮ:3 “Зунжин-7 буудал-МУБИС” чиглэлийн замналыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх үйлчилгээг 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдөж, чиглэлийн үйлчилгээний ажиллах цагийн хуваарийг боловсруулж, нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т, шөнийн цагаар ажиллах тээврийн хэрэгслүүдийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу нэгтгэн гаргахыг Улаанбаатар смарт карт ХХК /Юүн Жун И/-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/61 дүгээр, 2014 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/96 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

